



## “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН” ДАХЬ “ШАРГА АГТ ТАН” ХЭМЭЭХ ХЭЛЛЭГИЙН УТГА УЧИР

Б.Сүмбэр

Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим, МУИС  
Цахим шуудан: 1715277115@qq.com

Редакцид ирүүлсэн: 2017.05.15

### ХУРААНГУЙ

Нүүдэлчин ахуй, соёлтой Монгол үндэстэн моринд их хайртай. Монгол морь нь монголчуудын аугаа түүхийг бүтээлцэхэд хамт хүчин зүтгэж явсан сайн хань нь билээ. Монголчуудын дунд “Чингис (1162-1227)-ийн найман шарга” гэдэг ойлголт өргөн тархсан байдаг. Хятадын зураач Шиү Бэйхөн (徐悲鸿 /Xu Beihong/ 1895-1953) “Найман ажнайн зураг” (Eight Chin tar) хэмээх алдарт бүтээлээ Баруун Жөү улс (西周 /Xi Zhou/ МЭӨ 1046-МЭӨ 771)-ын 5-р хаан Жөү Мүван (周穆王 /Zhou Muwang/ МЭӨ 1054-МЭӨ 949)-гийн найман ажнай хүлгээс сэдэвлэн зуржээ. Харин “Жаргалын найман морь” сэдвээр уран зураг, баримал, сийлбэр хийдэг монголчуудын ойлголт “Чингисийн найман шарга”-тай холбоотой болов уу.

Энэ өгүүлэлд одоогоор мэдэгдээд байгаа Монгол хэл дээрх эх сурвалжуудаас 13-р зууны эхний хагаст бичигдсэн, гадны соёлын нөлөө бага туссан гэж үзэж болох “Монголын Нууц Товчоон” дахь «шарга агт тан» хэмээх хэллэгийг сонгон авч, дундад зууны үеийн “тан” дагаврын утга, хэрэглээний зарчмыг орчин цагийн Монгол хэлний үүднээс харьцуулан судалж, “шарга агт тан есөн морьд”, “шарга агт тан найман морьд” хэмээн бичиж байгаагийн цаана хэдэн шарга агт байсны тоо толгойг тогтоох, нүүдэлчин ахуй амьдралтай Монгол хүний танихуйн ухамсарт шар өнгө (зүсэм) хэрхэн бүрэлдснийг эрдэмтдийн судалгаанд тулгуурлан танихуйн хэл шинжлэлийн үүднээс тайлбарлаж, “Чингисийн найман шарга” хэмээх ойлголтын талаар тодорхой хариулт өгөхийг зорьлоо.

Түлхүүр үгс: Шарга агт тан, шар өнгө зүс, танихуйн хэл шинжлэл;

### ОРШИЛ

Монгол үндэстний түүх, уран зохиолын хосгүй үнэт бүтээл болох “Монголын Нууц Товчоон” (МНТ гэж товчилно) судлал нь Олон Улсын Монгол Судлал (IMS)-ын нэгэн чухал хэсэг бөгөөд монголчуудын ахуй ёс, төрт ёс, шашинт ёсны баялаг эх сурвалжийг хадгалсан энэхүү бүтээлийг үе үеийн судлаачид өргөн хүрээнд эрчимтэй

судалсаар иржээ.

Энэхүү өгүүлэлдээ МНТ-ны “шарга агт тан” хэмээх хэллэгийн утга учрыг танихуйн хэл шинжлэлийн үүднээс тайлбарлахыг оролдлоо. “Шарга агт тан” хэмээх үгийг гадаад дотоодын олон эрдэмтэд “шарга агт”, “шарга агт тан”, “шарга агттан”, “шарга морь”, “шарга морин”, “шарга



морьд” гэх мэтээр Хятад ханзын галиг эхээс хөрвүүлсэн байдаг ч тайлбар зүүлт, судалгаа шинжилгээ хийлгүй орхисон байдаг нь олонхи учраас энэхүү сэдвийг сонгон судлах шалтгаан болсон юм.

Энэ талаар судалсан Ш.Чоймаа “МНТ-ны *siqa aqta-tan* хэмээх үг хийгээд дундад үеийн Монгол хэлний *-tan* дагаврын судалгаа” хэмээх өгүүлэлдээ “шарга агт тан” хэмээх хэллэгийн утгыг монголчуудын шар өнгө, шарга зүсмийг эрхэмлэх сэтгэлгээ болон бөө мөргөлийн онгон шүтээндээ агт морь сэдэрлэх зан үйлтэй холбогдуулан дундад үеийн Монгол хэлний товчлон хураах, хүндэтгэх утгатай “*-tan*” дагавар [24, 94] хэмээн үзэж, нэг онгон шарга агт бүхий найман морь [24, 94] гэж тайлбарлажээ. М.Ууганбаяр магистрын зэрэг горилсон бүтээлдээ “шарга агт тан есөн морьд” гэдгийг “Данихүрэл” туулийг үндэслэн эрхэм сайны бэлгэдэл есийн тоо, хөнгөн шаламгай идэрхгийн бэлгэдэл шар цоохор, хуа цоохор зүстэй холбоотой 8 шарга морь, 1 шаргал агт гэж үзэж байна [17, 72] гэсэн бол Н.Бөххад “МНТ-ны шинжлэл” хэмээх номдоо нэг нь шарга бөгөөд энэ найман морьдын доторх онцгой зүсэмтэй морь байсан...бусад нь бүр агт буюу агт биш морьд байж болох...найман морьдын дотор шарга агт ганц л байсан [6, 177] хэмээжээ. Хасүми Хароу “Судар тэмдэглэл

Хүннүгийн намтар дахь нэгэн хэрэг” хэмээх өгүүлэлдээ МНТ-д бас адууны зүсэм нийлүүлж байсан тухай тэмдэглэл бий. Тэр нь даруй аугаа баатар Тэмүүжиний хувийн адууны тухай тэмдэглэл болно [19, 17] гээд “найман шарга агт” хэмээн ойлгожээ.

Урьдах судлаачдын судалгаа нь голдуу монголчуудын соёл заншлын үүднээс “шарга агт тан” хэмээх хэллэгийг тайлбарлах гэж оролдсон бол зохиогчоос нүүдэлчин ахуй соёл болон Монгол хүний танихуйг хамтад нь авч судлаад энэ хэллэгийн утга учрыг уламжлал, шинэчлэлийг уялдуулан тайлбарлахыг зорьсон нь шинэлэг тал хэмээн үзэж байна.

Гаднын соёлын нөлөөгөөр хэл, сэтгэхүй, танихуй, сэтгэлгээний хандлагад өөрчлөлт орж байгаа даяаршлын энэ үед үгийн утгыг зөв ойлгох, зөв хэрэглэх нь уугуул соёл, язгуур сэтгэхүйгээ хадгалан авч үлдэх баталгаа болох юм. Түүнчлэн МНТ мэтийн бусад үндэстний соёл бага тусгагдсан сурвалж бичиг дэх үг хэллэгийн утга судлал нь Монгол хүний хэл, сэтгэхүй, танихуйн гурамсан харьцааны зүй тогтлыг нээн илрүүлэх, өвөрмөц шинжийг судлан тогтооход чухал ач холбогдолтойгоор барахгүй тархи, мэдрэл судлалын хүрээнд хийгдэж байгаа эл судалгааны нэгэн хэсэг болох ёстой.

## АРГА, АРГАЧЛАЛ

Энэхүү судалгааг гүйцэтгэхдээ жишээ баримт цуглуулах, дүн шинжилгээ хийх, харьцуулан судлах, сонгон тайлбарлах,

задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргыг ашиглав.

## ҮР ДҮН

Судалгааны үр дүнг дараах гурван зүйлээр тодруулаж болно. Нэг, “шарга агт тан” хэмээх хэллэгийн “тан” дагавар орчин цагийн Монгол хэлэнд утга, хэрэглээ нь багассан байна. Хоёр, “шарга агт тан найман морьд” болон “найман шарга агт”

(Чингисийн найман шарга) хэмээх хэллэг хоорондоо утгын маш нарийн ялгаатай. Гурав, Монгол хүний язгуур ухамсарт бүрэлдсэн шар өнгө (зүсэм)-ний танихуйн зүйрлэлд нар, гал, алт (шороо) ордог.

**Нэг.** Орчин цагийн Монгол хэлэнд “-tan/ten” бүтээвэр нь жинхэнэ нэр (жинхэнэ нэр+tan/ten= жинхэнэ нэр, тэмдэг нэр+tan/ten= жинхэнэ нэр)-ийн утга, үүргээр идэвхитэй хэрэглэгдэж байна. Жишээлбэл: “авьястан”, “алдартан”, “амьтан”, “амттан”, “арьстан”, “араатан”, “атаатан”, “ачтан”, “баруунтан”, “буруутан”, “буянтан”, “гавьяатан”, “давхраатан”, “дархтан”, “журамтан”, “зоригтон”, “морьтон”, “мянгатан”, “настан”, “овогтон”, “овсгоотон”, “омогтон”, “оюутан”, “санаатан”, “санваартан”, “сахилтан”, “соёотон”, “судалгаатан”, “сурвалжтан”, “саятан”, “томоотон”, “туургатан”, “туурайтан”, “тушаалтан”, “угсаатан”, “ухаантан”, “хамаатан”, “хамсаатан”, “харьяатан”, “хариуцлагатан”, “холбоотон”, “цаатан”, “цагаантан”, “цолтон”, “чадалтан”, “чадвартан,

“шархтан”, “шашинтан”, “шуналтан”, “язгууртан”, “ялтан”, “ястан” [25, 767-771] гэх мэт. Эсргээр “tan/ten” дагаврын хэрэглээ харьцангуй багассан, зөвхөн хүндэтгэлийн утга илтгэх болсноос гадна бичлэгийн хувьд өөрчлөлт орсон шинжтэй байна. Жишээлбэл: “ахай-тан”, “багш-тан”, “ноён-тон”, “лам-тан”, “хаан-тан”, “гэгээн-тэн”, “эзэн-тэн” гэх мэт. Эндээс үзэхэд “tan/ten” дагавар, “-tan/ten” бүтээвэр олон тоог төлөөлөх, олон тоог товчлон хураах, хүндэтгэл илэрхийлэх утгаар хэрэглэгдэж байгаа нь тодорхой юм.

МНТ-д “Бэгтэр улхан дээр шарга агт тан есөн морьд харж сууж бүхүйд” (§77) хэмээн анх тохиолдох энэ “шарга агт тан” хэмээх хэллэг нийт 12 удаа (§77-1, §90-9, §205-2) хэрэглэгдэж, үг зүйн хэлбэр нь 5 янзаар бичигдсэн байна. Эдгээр хэллэгийг нэг бүрчлэн жагсаан харуулья:

1. “Шарга агт тан есөн морьд” хэлбэр 1 удаа:

失兒中合 阿黑(馬翳) 壇 也孫/yě sūn 秣舌驪惕/mò l(r)í tì  
慘白色 驢馬 等 九疋 馬每

2. “Шарга агт тан найман морьд” хэлбэр 4 удаа:

失兒中合 阿黑(馬翳) 壇 乃蠻/nǎi mǎn 秣舌驪惕  
慘白色 驢馬 等 八疋 馬每

3. “Шарга агт тан-ыг” хэлбэр 5 удаа:

失兒中合 阿黑(馬翳) 塔泥/tǎ ní  
慘白色 驢馬 等行

4. “Шарга агт тан-ы” хэлбэр 1 удаа:

失兒中合 阿黑(馬翳) 塔訥/tǎ nè  
慘白色 驢馬 等的

5. “Шарга агт тан” хэлбэр 1 удаа:

失兒中合 阿黑(馬翳) 壇 [4] гэх мэт.  
慘白色 驢馬 等

Энэ “失兒中合/shī ér h(k)é” (шарга) хэмээх үгийн хажуугийн орчуулгад “慘白/cǎn bái” (хувхай цагаан, цонхигор цагаан), “阿黑(馬翳)/ā hēi ta” (агт хэмээх энэ үгийн ТА гэдэг эргний ханз үсгийн фонт байгаагүй учраас энэ хоёр дан үсгийн нэгдэл гэж ойлгож болно) хэмээх үгийн хажуугийн орчуулгад “驢馬/shū mǎ” (агталсан морь, эсгэсэн морь), “壇/tán” (тан) хэмээх үгийн хажуугийн орчуулгад “等/děng” (зэрэг, мэт, нар, тэргүүтэн) гэж тайлбарласан байдаг.

Үүнээс үзвэл “тан” гэдгийг олон тооны хэсгийг хураах утгаар хэрэглэж, энэ “шарга агт тан” хэмээх хэллэгийг нэг цайвар гэгээн зүсмийн агт тэргүүтэй морьд байсан гэж ойлгож болно.

Дээрх хэллэгийн утгыг тодруулахад дундад зууны үеийн “tan/ten” дагавар, “-tan/ten” бүтээврийн утга, хэрэглээг судлахаас эхэлдэг учиртай. Түүнчлэн МНТ-ны зарим үг хэллэгээр жишээ болгож үзье.



## 1. “-tan/ten” бүтээвэртэй үг:

Овогтон	幹字黑壇/wò bó hēi tán 姓氏 每	Царайтан	赤舌來壇/chì l(r)ái tán 顏色 每
Тэргүүтэн	貼舌里兀田/tiē l(r)ǐ wū tián 等項	Өнгөтөн	汪格田/wāng gé tián 顏色 有的每
Халхтан	中哈勒中合壇/hā là h(k)é tán 圍牌 每	Өчилтөн	幹赤勒田/wò chì là tián 奏事 的
Суутан	速壇/sù tán 福 每有的	Засагтан	扎撒黑壇/zhā sā hēi tán 法度 有的
Залхамшитан	扎勒中含失黑壇/zhā là h(k)án shī hēi tán 怕了的	Номтон	弩木壇/nǔ mù tán 弓 共有的每
Ганцтан	中合黑察壇/h(k)é hēi chá tán 獨 每	Өлзийтөн	完勒者田/wán là zhě tián 吉慶 有的
Хястан	乞克田(壇)/qǐ kè tián 怨 有的	Ончтон	桓赤壇/huán chì tán 能號箭 的
Уурган	阿兀舌兒壇/ā wū ér(r) tán 剛氣	Хүчтэнийг	古出帖泥/gǔ chū tiē ní 氣力 有的行
Сүстэн	雪勒速壇(田)/xuě là sù tán (tián) 膽 有的	Омогтон	幹抹黑壇/ wò mò hēi tán 勇 有的
Турастан	秃舌刺思壇/tū l(r)à sī tán 方牌 有的每	Итгэлтэн	亦帖格勒田/yì tiē gé là tián 中倚附 的
Унааган	兀訥阿壇/wū nē ā tán 單騎 的有	Нөмөртөн	捏木舌列田/niē mù l(r)ìè tián 遮蔽 的
Хишигтэн	客失克田/kè shī kè tián 宿衛 的	Гэрэлтэн	格舌列田/gé l(r)ìè tián 光有 的
Муутан	卯兀壇/mǎo wū tán 歹 每有	Барааган	巴舌刺秃壇/bā l(r)à tū tán 暗 每有
Мялааган	米納阿壇/mǐ nà ā tán 做鞭 有的	Эрдэмтэн	額兀迭迭木田/é ér(r) dié mù tián 技能 每有的
Сайтан	撒亦壇/sā yì tán 好 的每	Галтан	中合勒壇/h(k)é là tán 火 有的
Магнайтэн	莽來壇/mǎng lái tán 額顛 有的	Хошуутан	豁失兀壇/huō shī wū tán 嘴 有的
Хэлтэн	客列田/kè liè tián 舌 有的	Өртөн	幹舌列田/wò l(r)ìè tián 心 有的
Юутан	牙兀壇/yá wū tán 甚麼 每	Туургатаныг	秃兀舌兒中合塔泥/tū wū ér(r)h(k)é tā ní 帳牆 有的
Үүдтэнийг	額兀迭帖泥/é wū dié tiē ní 門 有的每行	Ёстоныг	約速塔泥/yuē sù tā ní 理 有的每行
Алдалтан	阿勒荅勒壇/ā là dá là tán 罰 有的	Харьяатан	中合舌里牙壇/h(k)é l(r)ǐ yá tán 親屬 的每
Сэтгэлтэн	肆惕乞勒田/sì tì qǐ là tián 心 有的每	Байдалтан	擺亦荅勒壇/bǎi yì dá là tán 立 有的每
Явдалтан	迓步荅勒壇/yà bù dá là tán 行 的每	Гоотон	中豁阿思壇/h(k)uō ā sī tán 美 每有

Хонхотан	中晃中豁壇/h(k)uǎng h(k)uō tán 種	Нутагтан	嫩秃黑壇/nèn tū hēi tán 營盤 有的每
Балгастан	巴刺中合速壇/bā là h(k)é sù tán 城子 有的每	Цулайтан	捌刺亦壇/shuò là yì tán 空缺
Устан	兀速壇/wū sù tán 水 有的	Алттан	阿勒塔壇/ā lè tā tán 金 有的
Эгтэн	額耶田/é yē tián [4] гэх мэт. 商議		

## 2. “tan/ten” дагавартай хэллэг:

“Чарахай Линхугийн хөвүүн Сэнгүм Билгэ, Амбагай тан~壇/等” (§47), “Таргудай Хирилтуг, Төдөгэн Гиртэ тан~壇(田)/等” (§72), “Тэмүүжин, Тоорил хан, Жаха Гамбу тан~壇/等” (§108), “Мэнгэтү Хианы хөвүүн Өнгүр тан~壇(田)/等” (§120), “Чингис хаан, Өгээлүн Үжин, Хасар, Жүрхиний Сэчэ Бэхи, Тайчу тан~壇/等” (§130), “Хонгирадын Тэрхэг, Эмэл, Алхуй тан~壇/等” (§141), “Тайчуудын Таргудай Хирилзүг, Хотун Өрчэн, Агучу Баатар тан~壇/等” (§141), “Алтан, Хучар, Сэнгүм тан~壇(田)/等” (§142), “Агучу Баатар, Хотун Өрчэн, Хутугудар тан~壇/等” (§148), “Алаг, Наяа тан Ширгээт өвгөний хүвгүүд~壇/等” (§149), “Эл Хутур, Хулбари, Аран Тайш тан дүү нараа~壇/等” (§149), “Боорчу, Мухали тан ноёдыг уриж ирүүлэж~壇/等” (§156), “Егү Есүнхэ Туху тан гурван хүвүүдээ~壇/等” (§183), “Боорчу, Мухали тан хэнээс үлүү тус хийлээ~壇/等” (§203), “Боорчу, Мухали тан ноёдыг уриж оруулжуу~壇/等” (§203), “Боорчу Мухали тэрүүтэн ноёд, Дөдэй Доголху тан чэрбинээ~壇/等” (§210), “Толун тан лугаа төвлөн суутугай~壇/等” (§213), “Есүнтэгэ, Бүгидэй тан хорчныг ихэс хорчин хэмээгтүн~壇(田)/等” (§230), “Есөндэхэ, Бүхидэй тан хорчин~壇(田)/等” (§234), “Алчидай, Өгэлэ, Ахудай тан турхагууд~壇/等” (§234), “Буха, Дөдэй чэрби, Доголху чэрби, Чанай тан турхагууд~壇/等” (§234), “Боорчу Мухали тан ийн эс дуртгав~壇/等” (§254), “Ирү, Исабур тан балгад авч~壇/等” (§259), “Хонхордай, Ширахан тан засуул~壇/等” (§278), “Мөнгэй, Алчидай, Хонхордай,

Жанги тан-аа~塔納/tǎ nà/等行” (§277), “Тэмүүжин, Тоорил, Жаха Гамбу тан-ны~塔納/tǎ nè/等的” (§108), “Жамуха, Алтан, Хучар тан-ы~塔納/tǎ nè/等的” (§246), “Саалчин тан-ыг~撒阿鄰臣塔泥/sā ā lín chén tā ní/擠馬每的行” (§279), “Нутагч тан-ыг~嫩秃赤塔泥/nèn tū chì tā ní/管營盤的行” (§279), Хятад иргэний Алтан хаан, Мэгүжин Сүүлт тэн~田/等 (§132), “Эрдмүүд тэн~額舌兒迭木楊田/é ér(r) dié mù tì tián/技能每有” (§139), Тэрэг, Эмэл тэн Онгирууд~田/等 (§176) [4] гэх мэт.

Дээрх хэллэгт дүн шинжилгээ хийхэд доорх гурван үр дүн харагдана:

1. “tan/ten” дагавар, “-tan/ten” бүтээврийг Хятад ханз үсгээр галиглахдаа эр үгэнд “壇/tán”, “塔泥/tǎ ní” бичиж, эм үгэнд “田/tián”, “帖泥/tiē ní” хэлбэрийн дүрмийг баримталж бичсэн нь харахад тодорхой зүйл ч зарим цөөхөн үгэнд энэ зарчим алдагдсан буюу алдаатай бичсэн тохиолдол бас байна.
2. “tan/ten” дагавар нь ихэнх тохиолдолд хүний нэрний (оноосон нэр) ард салангид хэрэглэгдэж, олон тооны товчлон хураах утгыг илэрхийлж байгаа нь илхэн байна. Орчин цагийн Монгол хэлний хэрэглээнд байгаа шиг хүндэтгэлийн утга нь төдийлөн тодорхой биш байна. Хажуугийн орчуулга “等/děng” хэмээх үг нь “ээрэг, нар, тэргүүтэн, гэх мэт” гэсэн товчлон хураах утгыг илтгэх ханз үсэг болно.
3. “-tan/ten” бүтээвэр нь “-tai/tei+n” хэлбэрээс гаралтай “-n” бүтээврийн олон тооны утга илэрхийлэхээс гадна бас юмны шинж байдал заасан “-du/tu+n”, “dū/tū+n” хэлбэрийн тэмдэг



нэрийн үүргээр хэрэглэгдэж байна. Хажуугийн орчуулга “有的每行/yǒu de měi háng” хэмээх үгийг салгаж ойлговол “有/yǒu” гэдэг нь “байх, байна”, “有的/yǒu de” гэвэл “байгаа байна”, “每/měi” гэдэг нь “болгон, бүр, тутам”, “每行/měi háng” гэвэл “нэг болгон нь, нэг бүр нь, нэг тутам нь” гэсэн утгыг тус тус илтгэдэг.

Ш.Чоймаа дээрх өгүүлэлдээ “tan/ten” дагавар, “-tan/ten” бүтээврийн талаар эрдэм шинжилгээний өндөр түвшинд гүнзгийрүүлэн судалж, 7 зүйлийн санал дэвшүүлсэн байгааг харьцуулан үзье:

1. Илтгэх утгаараа ялгаатай.
2. Хэл зүйн хэлбэрийн хувьд олон тоот тэмдэг нэр бүтээдэг “-tan” дагавар нь эм үгэнд залгахад “-ten” гэсэн хувилбартай байсан бол нөгөө “tan” нь нэг л хувилбараар тохиолдоно.
3. Гарлын тухай мөн ялгаатай.
4. Зөв бичих дүрмийн талаар олон тоот тэмдэг нэр бүтээдэг “-tan” дагаврыг ихэнхдээ хамт бичиж, нөгөө “tan” дагаварыг салангид бичдэг.
5. Ямар үгэнд залгаж үг бүтээдгээр нь ялгаж болно.
6. Энэ хоёр зүйлийн “tan, -tan” дагаврын орчин цагийн Монгол хэлэнд үг бүтээх утга нь улирч өөрчлөгдсөний сацуу хэрэглэгдэх хүрээ, бүтээлч шинж нь ч адилгүй болжээ.
7. МНТ-ны Хятад галигийн хажууд хадсан энэ хоёр зүйлийн “tan, -tan” дагаврын Хятад орчуулга нь тогтвортой ялгасан өөр өөр үг байдаг [24, 80-83].

Судалгааны үр дүнгээс үзвэл МНТ бичигдэж байх үед “tan/ten” дагавар эр, эм үгийн зохицол оршиж байсан, Хятад ханз үсгээр галиглах тэр цаг үед буюу галиглах явцад энэ зарчим мөн үйлчилж байжээ. Эсвэл энэ зарчим алдагдсан, алдаатай галигласан буюу хожмын хүмүүс алдаатай хуулбарлсан байж болох магадлалтай учраас “нөгөө “tan” нь нэг л хувилбараар тохиолдоно” гэж дүгнэлт гаргах нь эргэлзээтэй зүйл болно.

**Хоёр.** Залгаад МНТ-ны эл хэсгүүдэд гарах “агт” хэмээх үгийн олон тооны хэлбэрийг харьцуулан шинжлэе. Үүнд “Алчидай-н агтас адуулсан Чихидай, Ядир зүйл зүйлийн ногоонд агтсаа адуулан явахуйд...агтсаа үлдээд ирэж...агтсаа бариулан” (§170), “сөнөд агтсаа барьж хонож” (§172), “агтас мин үелбэй” (§177), “агтас бидний турхууд буй...Агтас турхууд хэмээн яахан шалтагдах! Миний агтас тарган буй” (§190), “буурч, үүдэч, агтач өдөр хишиг орж, наран шингэхийн урьд хэвтүүлээ зайлж агтастаа гаран хонотугай” (§192), “Монголын агтас турхууд ажуу... агтасаан цадтал энэ Саарь хээрийг дэлгэн бууж... бидны агтас бээр цадмуй зэ. Агтсаан цатган Найманы харуулыг үлдээд” (§193), “Монголын агтас турхууд ажуу... Монголын агтас турхун хэмээгдмүй... бидний агтас тарган буй... Монголын агтас цанхадуулан нүүр дээр нь асгая бид” (§194), “анд сэцэн эхт, төрөлх хүлэг төрж, эрдэмтэн дүү нарт, өрлөгүүд нөхдөөрөө далан гурван агтсаараа болж” (§201), “агтсаа асарч, өөшин ачиж явтугай” (§234), бас “цагаа нууд шонхууд, цагаа нууд агтас, хар нууд булгад” (§239) [4] гэх мэтээр бичиж байдаг. Энэ зарчимд тулгуурлавал “шарга агт тан” хэмээх хэллэгийг “шарга агтас” буюу “шарга нууд агтас” хэмээн бичих ёстой билээ. Харин тоо толгой нь тодорхой есөн морьд байсан учраас “-с” хэмээх олон тооны бүтээврээр хэлбэржээгүй бөгөөд олон тооны утга илтгэх “-tai/tei+n” гаралтай “-tan” бүтээвэр биш болох нь тогтоогдож, есүүлээ агталсан шарга морьд биш байсан нь ч батлагдаж байгаа юм. Тийм биш байсан бол “есөн шарга агттан”, “найман шарга агттан” гэсэн хэлбэрээр бичих ёстой болно.

Монголчуудын дунд мал онголон сэдэрлэх зан үйл уламжилсаар одоо хүрчээ. Тэгвэл “шарга агт тан есөн морьд”-ын дунд нэг онгон сэдэртэй нэг морь байсан уу? Энэ онголж сэтэрлэх зан үйл нь Монгол оронд бурхан шашин дэлгэрсэн цагаас хойших бурхан шашны энэрэл нигүүлсэхүй, амь хороохыг цээрлэдэг

номлол сургаалын нөлөөнд үүссэн гэдэг үзэл баримтлалтай санал нэг байдаг учраас бөө мөргөлийн зан үйлтэй холбогдуулан тайлбарлах нь төдийлөн оновчтой биш болов уу. Мөн сэтгэртэй мал адгуусыг “тан” хэмээн хүндэлж байсан гэж хэлэхэд нэн үнэмшил багатай юм. Түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн Өгөдэй хаан (1186-1241)-ы үеэс байсан цагаан гэрүүдээ “Найман цагаан гэр” хэмээн шүтэн [16, 70] одоог хүртэл уламжлагдаж ирсэн Өвөр Монголын Ордос нутагт байдаг “Чингисийн Онгон”-д тайллага тахилга болоход шүтэж байгаа онгон сэдэртэй морийг “Өндөгөн цагаан” гэдгээс биш “Өндөгөн цагаан тан” хэмээн нэрийдээгүй юм. Зарим нэгэн судлаачид Тэмүүжин Мэргидийн довтлолоос зугтаж зайлах үед нэг моринд хөтөл зассанаас болоод Бөртэ Үжин-д морь дутсантай холбон нэг онгон сэтгэртэй морь байсан гэх таамаг дэвшүүлсэн байдаг. Энэ таамаг бодит байдал дээр нийцэхгүй хоёр зүйл ажиглагдаж байна. Нэг нь, Мэргид-ийн довтлолт болох үед “шарга агт тан есөн морьд” байснаас гадна Боорчу-ын унаж ирсэн бөгтөр хонгор нийлээд 10 морь байсан учраас Бөртэ Үжин-д морь дутах бололцоогүй юм. Хоёр нь, Монголчуудын цээр ёсонд онголон сэтэрлэсэн мал адгуусаа унаж эдлэхийг бүү хэл, цохиж хараахыг ч хатуу хориглодог учраас хөтөл зассан тэр морь онгон сэтгэртэй морь байх ёсгүй юм. Иймээс энэ “шарга агт тан” хэмээх хэллэгийн “тан”-д хүндэтгэлийн утга алга байна.

Монголчуудын хэлдэг шарга хэмээх зүсэм нь адууны эх бие толгой нь шаргал, дэл сүүл нь шаргал цэгээн зүсэм. Эх биеийн үс нь шаргал, сор ба үсний үзүүр нэлээд улаавгардуу болохоор үс сорын үзүүрт улаан шаргал гялбаа татдаг. Яг намрын шар тос шиг өнгөтэй бол улаан шаргал зүсэм. Улаан шаргыг бодвол нэлээд цэгээн шар байвал цагаан шарга зүсэм гэхчлэн ялгана. Бас эх бие нь цэгээн шаргалдуу, үсний үзүүр болон сор нь алтан шаргал холимог гялбаадах бол бор шарга зүсэм.

Бор шаргыг бодвол боровтор шаргал нь гүн шиг, яг сая түлсэн аргалын галын утаа шиг зэвхий саарал шаргал өнгөтэй бол утаан шарга зүсэм. Хулсан өнгө адил шаргал бол хулсан шаргал зүсэм. Ухаа шарга, цагаан ухаатай ойролцоо бол хонгор шарга зүсэм [11, 22] хэмээдэг. МНТ-д “шарга агт тан есөн морьд” (түүний нэг нь оготор дарги хонгор)-оос гадна Чилэдү-ийн хурдан хув, Боорчу-ын хурдан хув, бөгтөр хонгор мэтийн шаргалдуу гэгээн зүсмийн морьд харьцангуй илүү дүрслэгдсэн байдаг нь монголчуудын шаргал зүсмийн адууг эрхэмлэдэг хүндлэн дээдлэхийн утга, ...хур хүч, тарга тэвээр алдахгүй, ...холыг туулах шандастай, унахад аятай бахтай, ...уналга сайтай, зорьсон газар хүргэгч, ...ааш авир, төрх байдал сайн [8, 78-80] сэтгэлгээний үнэлэмж, танихуйн туршлагатай холбоотой юм. Хүн төрөлхтний эрт балрын үед нар болон галыг шүтдэг байснаас үүдэлтэй гэрэл гэгээ, хайр хамгаалал, халуун дотно, аз жаргал, рид хувилгааны төлөөлөл болгон ойлгодог танихуйн ухамсар шар өнгө (зүсэм)-нд хадгалагдан үлджээ. Хожим нь Монгол оронд шарын шашин дэлгэрснээс хойш шар өнгө нь бүр илүү эрхэмлэгдэн дээдлэгдэх болсон бөгөөд гэгээн хувилгаад лам хувраг нарт хүндэтгэл илэрхийлэх бэлгэ дэмдэг болсон байна. Судлаач О.Нандин-Эрдэнийн “Дохио үг → Хариу үг” гэсэн туршилтын явцаас харахад шар өнгө хамгийн их хариу үгтэй, өндөр давтамжтай (300 хүн энэ өнгөнд 65 төрлийн 596 давтамжтай хариу ирүүлсэн) байгаа нь монголчууд өнгөний нэрийг үүсгэхдээ амьдрал, ахуйдаа буй олон зүйлд хандаж өнгө нэрлэдэг, хүний сэтгэхүйд хамгийн түрүүнд алтан шар гэсэн хариу үг буусан байгаа нь монголчууд шар өнгө харангуут алттай авалцуулан зүйрлэдэг, ... алтан шар нар гэдгээс үүдэлтэй бэлгэдлийн чанартай [13, 90] байх шар өнгө Монгол хүний танихуйд өргөн цар хүрээтэй цогц ойлголт учраас харьцангуй илүү мэддэг, илүү таашаагддаг өнгийн нэг болж хэвшин тогтжээ.



Энэ есөн морьдыг “оготор дарги хонгор тан” гэж бичсэнгүй, харин түүний доторх шарга зүсмийн агталсан нэг мориор (шарга зүсмийн агт бүхий есөн морьд) тодотгож байгаа нь дээр өгүүлсэн шар өнгийн тухай Монгол хүний танихуйн туршлага, сэтгэлгээний үнэлэмжтэй зайлшгүй холбоотой юм. Хүний танихуйн үйл үүсэхэд биед хамгийн ойрхон байдаг, өөртөө хамгийн сайн мэддэг зүйлээс жишин адилсуулах, авалцуулан холбох, зүйрлэн хураах зарчим үйлчилдэг байна. Жишээлбэл: “уул” хэмээх үг нь алсаас харахад “агуу зүйл, агуу юм” гэж сүрдэн биширч байснаасаа ойртохоороо “уулын толгой”, “уулын хамар”, “уулын ам”, “уулын суу”, “уулын сүвээ”, “уулын хормой”, “уулын өвөр”, “уулын энгэр”, “уулын ар” гэх мэтээр биед суурилсан ухамсарт танихуйн цогц ойлголт, танихуйн орон зайн ойлголт үүсэн бүрэлдхийн хамт цогц мэдлэг бий болдог. Эндээс Монгол хүний ертөнцийн түмэн бодисыг амьтай хэмээн “Хүнчилдэг” танин мэдэхүйн шинж онцлог харагдаж багаа юм. Нэгэн адилаар зүс нь үл ялгарах холоос ойртох адуун сүрэгт шаргал зүсэм нь илт тодрон танигдаж эхэлдэг танихуйн туршлага болон Монгол хүний үлгэр, домог, туульсын баатар адуулдаг адуун сүрэг, унадаг хий хүлэг мориныхоо шарга, шаргал зүсмийг эрхэм болгодог [8, 78] сэтгэлгээний таашаалаас шалтгаалан шарга зүсэм нь онцын содон сайхнаар төсөөлөгддөг рид хувилгаантай гэж ойлгодог байсан язгуур ухамсрын үр нөлөө юм. Шинжлэх ухааны нээлтээр хайн илрүүлж, амьдрал ахуйд нэвтрүүлж байгаа авто замын гэрлэн дохионы шар гэрэл, сургуулийн хүүхдийн автобусын шар өнгө, бусад машин төхөөрөмжийн аюулаас сэргийлэх дуут дохионы гэрэлд шар гэрэл сонгож ашигладаг нь шар өнгийн гэрэл үүл манан, цас бороо, салхи шуурга, шороо тоостой үзэгдэх орчны хязгаарлагдмал байдлаас үл шалтгаалан илүү хол тархдаг, нэвтлэх чадвар сайн шинж чанартай байдгаас болсон юм. Манай өвөг дээдэс аль язгуур нүүдэлчин амьдралаасаа энэ шинж

онцлогийг танин мэдэж, холыг харах дуран байгаагүй эрт үед холын бэлчээртэй адуун сүргээ шарга зүсэм ашиглан ялгаж танидаг байсныг үгүйсгэхгүй.

Монголчуудын мал малжихын арга ухаан, амьдрал ахуйн ёс уламжлалд салхи шуурганд уруудаж төөрсөн, сүргээсээ салж газарласан, эсвэл дээрэм хулгайд алдаж гээсэн адуу малаа им тамга буюу аль нэгэн содон зүсмээр сураг гаргадаг. Энэ уламжлалыг мөрдвөл Тэмүүжин дээрэмд алдсан найман морио Боорчу-оос иймэрхүү байдалтай асууж байсан гэж бодвол энэ есөн морьдын дотор онцын содон шарга зүсмийн агталсан нэг морь байсан гэж дүгнэхэд хүргэнэ. Гэхдээ дээрэм ирж “шарга агт тан найман морьд”-ыг дээрэмдсэн үйл явдал нь Бэгтэр-ийг нас барснаас хойно болсон учраас “шарга агт тан есөн морьд” хэмээх анхны тохиолдолтой зөрчилдөнө. Нүүдэлчин үндэстэн мал сүргээ зүс ижилшүүлэн өсгөн үржүүлж, эдэлж хэрэглэж байсан нь баатарын тууль, үлгэр домог, ерөөл магтаалын үг хэллэгт гардаг бөгөөд зарим түүхэн сурвалжид бас харагддаг. Жишээ нь: “Судар тэмдэглэл”-ийн 110-р боть, Хүннү-гийн намтарын 50-рт доорх мэт тэмдэглэл бий: ... Хүннү-гийн морьт цэрэг ину өрнө бүхнээр саарал морь, дорно бүхнээр бор морь, умар бүхнээр хар морь, мөнө бүхнээр улаан морь [19, 9] жагсааж байсан гэж тэмдэглсэн бол, өөр нэгэн Хятад сурвалж Ван Тиндэ-ийн “То Цанд элчилсэн тэмдэглэл”-д тоорх мэт тэмдэглэл буй. Даруй тэр газарт адуу олон. ... Зүсээр нь ялган адуулдаг [19, 19] хэмээн тэмдэглэжээ. Адууны үндсэн зүсний нэг хонгор зүс нь ухаа шар өнгөтэй байх бөгөөд ухаа хонгор, хул хонгор, цайвар хонгор, хул гэх мэт ялгаатай. Ухаа хонгор морины дэл сүүл улбар шар, их бие нь ухаа шар, өөр зүсний хольцгүй байна. Цайвар хонгор нь дэл сүүл сагаг болон суга хонгор зэрэг нимгэн газраар цайвар байна. Хул зүс нь бол их бие нь хул хонгор, дэл сүүл хар буюу холимог, хулан шиг байдаг [9, 183] учраас шарга агт, оготор дарги хонгор хоёрыг



багтаасан эдгээр есөн морьд алаг, бараан биш, харин гэгээн цайвар зүсмийн адуу байсан юм.

Энэ “шарга агт тан есөн морьд” Есүгэй Баатарыг нас барсны дараа түүний өнчин хоцорсон эхнэр хүүхдийн гол амь зуулга “адуусан идээн” болж байсан, мөн Бэгтэр-ийн өмч мэдэлд байснаар анх тэмдэглэгдсэн зэргээс үзвэл Бэгтэр-ийн амиа алдах шалтгааны нэгээхэн хэсэг ч энэ есөн морьдын өмч хөрөнгийн зөрчил байж болох юм. Эдгээр морьд “гэрийн дэргэд байж бүхийг дээрэм ирж, үзгэл дээрэмдэж” явсан нь холын бэлчээртэй хур адуун бол биш, харин “тарвага ачиж, нягсгалзтал явган хөтөлж” ирдэг хүнд хүчир ажилд байнгын унаж эдэлдэг морьд байжээ. Энэ есөн морьд нь холын замд эцэж цуцдаггүй, эр хүчтэй, шандаст хурдан хүлгүүд байсныг Тэмүүжин дээрэмдүүлсэн морьдын хойноос ганцаар “гурав хоног” явсан ба Боорчу-той хамт “гурав хоног” явсан, бас дээрмээс буцаагаад “гурван өдөр гурван шөнө” зогсолтгүй явснаар дүрслэж байгаагаас мэдэж болно. Үүнээс гадна “Хиад иргэний” Есүгэй баатарын

үр удмын угсаа гарал, нэр төр, хүндэтгэл бишрэл, эрх мэдлийн илэрхийлэл болгож, бөө мөргөлийн 99 онгод тэнгэрийн есийн тооны бэлгэдэл шингэсэн есөн морьдыг зүс нийлүүлэн тэжээн арчлаж байсан бөгөөд энэ “шарга агт тан” хэмээх хэллэгийн “тан” нь хэсгийн олон тооны хураах утгаар хэрэглэгдэж байх дагавар болно.

Монгол хэлний зарим нутгийн аялгуунд “tan/ten” дагавар одоо ч гэсэн идэвхтэй хэрэглэгдсээр байгаа юм. Нутгийн аялгууг дагнан судалсан Г.Гантогтох ярихдаа Буриад аялгуунд эдүгээ ч хүний нэрийн ард “tan” дагавар залгаж, жишээ нь: Базар тан манайхаар айлчилж ирээ (Базар тэргүүтэн гэр бүлээрээ манайхаар айлчлалаж ирсэн) гэж ойлгогдохоор ярилцдаг [1] хэмээн ярьж байсан юм. Энэ нь Буриад аялгуунд “tan” дагавар хэсгийн хураах утгаар хэрэглэгдэж байгааг батална. Энэ дашрамд МНТ-ны үг хэллэгийн утга, хэлбэрийг бүрэн зөв ухааран ойлгох, тайлбарлан тодорхойлоход Монгол үндэстний оршин амьдарч байгаа эл газар нутгийн хэл аялгуу, амьд яриаг анхааран шинжлэх чухал болохыг тэмдэглэе.

## ДУГНЭЛТ

Судалгаанаас харахад доорх дүгнэлтэд хүрч байна:

1. Энэхүү “шарга агт тан” хэмээх хэллэгийн “тан” бол “-tai/tei+n” гаралтай олон тооны утга илэрхийлэх бүтээвэр “-tan” биш юм.

2. Орчин цагийн Монгол хэлний хэрэглээн дэх хүндэтгэлийн утга илэрхийлэх “tan” бүтээвэртэй харьцуулбал салангид бичиж дагаврын шинжтэй хэрэглэгдэж, хүндэтгэлийн утга нь харьцангуй идэвхгүй хэрэглэгддэг байна.

3. Хэсгийн олон тооны товчлон хураах утга илтгэх “tan” дагавар бөгөөд хэсгийн хураах утга нь ихээхэн идэвхитэй хэрэглэгдэж байжээ.

4. Есөн морьдын дунд шарга зүсмийн агталсан нэг морь лавтай байхаас гадна

зургаан шарга агт байж болох буюу бусад нь оготор дарги хонгорын нэгэн адил гэгээн цайвар зүсмийн морьд байв. Тиймээс “Чингисийн найман шарга” гэдэг ойлголт МНТ дахь “шарга агт тан найман морьд” хэмээх хэллэгээс улбаатай боловч бодит үнэнд нийцэхгүй, харин Монгол хүний сэтгэлгээний хандлагаас үүссэн шарга зүсэм, тоо буюу зүг чиг (дөрвэн зүг найман зовхис)-ийг илтгэсэн “Жаргалын найман морь” хэмээх хийсвэр ойлголтын эх дүр [14, 191-192] мөн.

5. Шар өнгө нь Монгол хүний танихуйд сайн мэддэг, илүү таашаагддаг нар, гал, алт (шороо)-аар зүйрлэгдэж, нар шиг гэгээн гэрэлтэй агуу, гал шиг авран хамгаалах хүчтэй, алт шиг аз хурайлах эрхэмсэг, шороо мэт хүн байгалийн



оршихуйн билиг оюуны бэлгэдэл утга санааг шингээжээ.

6. Холын замд эцэж цуцдаггүй, эр хүчтэй, шандаст хурдан хүлгийн шинжийг

бүрдүүлсэн шарга, шаргал зүсмийн адууг ихэс язгууртан, баатар хүчтэн, баян хүмүүс унаж эдэлдэг байжээ.

## НОМ ЗҮЙ

1. “МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн багш Г.Гантогтохтой хийсэн ярилцлага.” Б.Сүмбэр. Хувийн Тэмдэглэл. УБ. 2016/5/1.
2. Бадамдорж. Д. Монгол Хэлний Үгийн Сангийн Утга Зүй. УБ. 2015.
3. Баянсан. Ж. Соёл, Хэл, Үндэстний Сэтгэлгээ. УБ. 2002.
4. Баяр. Монголын Нууц Товчоон (МНТ). Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо (ӨМАХХ). 2012.
5. Баяр. Ян. Монгол Аман Зохиолын Үндсэн Төрөл Зүйл ба Морьны Дүрийн Соёл Зүйн Судлал. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо (ӨМСХХХ). 2005.
6. Бөххад. Н. Бэлгүүдэй. МНТ-ны Шинжлэл. УБ. 2010.
7. Дугаржав. Хуасай. МНТ-ны Харгуулан Хянасан Дэвтэр. Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо (ӨМСХХ). 1984.
8. Дулам. С. Өнгийн Бэлгэдэл Зүй, Зүг Чигийн Бэлгэдэл Зүй. Монгол Бэлгэдэл Зүй. II. УБ. 2007.
9. Жамбалдорж. С. Морин Эрдэнэ. УБ. 1996.
10. Мансан Тайчууд. Шинээр Орчуулж Тайлбарласан МНТ. Өвөр Монголын Шинжлэх Ухаан Теник Мэрэгжлийн Хэвлэлийн Хороо (ӨМШУТМХХ). 2007.
11. Монгол Зан Үйлийн Нэвтэрхий Толь. Бүрэнтөгс нар. Аж Ахуйн Боть. ӨМШУТМХХ. 1997.
12. Мостарт Антоон. МНТ-ны Зарим Үг, Хэсгийн Тухай. УБ. 2010.
13. Нандин-Эрдэнэ. О. Өнгө Заасан Нэрийг Сэтгэц Хэл Шинжлэлийн Үүднээс Судлах нь (Диссертац). УБ. 2015.
14. Нансалмаа. Н. болон Долгор. С. Танихуйн Хэл Шинжлэл. УБ. 2014.
15. Орчин Цагийн Монгол Хэл. УБ. 2004.
16. Сайнжаргал. Монгол Тахилга. Үндэстний Хэвлэлийн Хороо (ҮХХ). 2001.
17. Ууганбаяр. М. МНТ-ны Зарим Үг Хэллэгийн Тайлбар (Магистрын ажил). УБ. 1996.
18. Хангай. МНТ-ны Соёл Судлал. ӨМАХХ. 2004.
19. Хароү. Хасүми. “Судар Тэмдэглэл Хүннүгийн Намтар тахь Нэгэн Хэрэг.” МНТ-ны Аман Зохиол Судлал. ӨМСХХ. 1999.
20. Хишигбат. Хишигбатын Орчуулсан Юан Улсын Нууц Товчоо. ӨМАХХ. 2001.
21. Хөгжих. Монгол Ардын Аман Зохиолын Уран Дүрийн Судлал. ҮХХ. 2004.
22. Цэдэв. Д. МНТ-ны Бэлгэдэл Зүй. УБ. 2002.
23. Цэрэнсоднам. Д. МНТ-ны Орчуулга Тайлбар. ҮХХ. 1993.
24. Чоймаа. Ш. “МНТ-ны *sirqa aqta-tan* хэмээх Үг хийгээд Дундад Үеийн Монгол Хэлний -*tan* Дагаврын Судалгаа.” МНТ хийгээд Монгол Сурвалж Бичгийн Судлал. ӨМАХХ. 2007.
25. Чоймаа. Ш. Баярсайхан. М. нар. Монгол Бичгийн Хэлний Тонгоруу Толь. Хөх хот. 2006.
26. Чоймаа. Ш. МНТ Эртний Үг Хэллэгийн Түгээмэл Тайлбартай Шинэ Хөрвүүлэг. УБ. 2011.
27. Элдэнтэй болон Ардаажав. МНТ Сийрүүлэл тайлбар. ӨМСХХХ. 1986.



## THE MEANING OF WORD “SHARGA AGT TAN” IN “THE SECRET HISTORY OF MONGOLIA”

*B.Sumber*

*Mongolian Language and Linguistics Department, National University of Mongolia  
corresponding author: e-mail: 1715277115@qq.com*

**Abstract:** Horses are loved by Mongolians in their culture and nomadic lifestyle. Mongolian horses made a great contribution to Mongolian history.

The art work of ‘The Eight Steed of Genghis’ is well known by us. While Chinese artist Xu Beihong (1895-1953) great work ‘Eight Chun map’ has its root in West Zhou Dynasty’s (B.C. 1046-B.C. 661) art work which was drawn by fifth king Zhou Muwang (B.C. 1054-B.C. 949). Similarly there maybe a connection between the ‘Lucky Eight Horses’ in art works even sculptures with the Mongolian art called ‘The Eight Steed of Genghis’.

This article aims to explain the meaning of the word ‘Sharga agt tan’ as used in “The Secret History of Mongolia” which was written in the 13th century, is considered to have no outside influences and believed to be an accurate account of Mongolian history. It especially aims to explain the meaning of the suffix tan that is used in the phrase ‘Sharga agt tan’ in “The Secret History of Mongolia”. The suffix tan was used in the middle aged Mongolian language and in our study you can see the comparison of the suffix tan and its similar meaning in contemporary Mongolian language. This article also aims to determine the actual number of horses in the phrase such as ‘Sharga agt tan 9 morid’ (meaning of nine yellowish/ light bay horses), ‘Sharga agt tan 8 morid’ (meaning of eight yellowish/ light bay horses), as well it attempts to explain that in the mongolian language the word sharga means yellowish/light bay colour in cognitive linguistic understanding. This study also explores the meaning of the expression ‘The Eight Sharga Steed of Genghis’.

**Keywords:** Sharga agt tan (meaning of yellowish/light bay horses), yellowish or light bay colour, Cognitive Linguistic;